



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/246

Булган сум

“Соёлын түүчээ 2025” арга хэмжээг
зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн соёлын салбарын ажилтан, албан хаагчдад зориулсан “Соёлын түүчээ 2025” уулзалт, хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 09-10-ны өдрүүдэд зохион байгуулахад 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР